



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018. 02.06 № 10

Асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газар Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/ хоорондын хөнгөлөлттэй зээлээр Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг "Хөшигийн хөндий"-д баригдаж буй Олон улсын шинэ нисэх буудал 2018 оны 10 дугаар сараас бүрэн ашиглалтад шилжихээр төлөвлөгдсөн байна. Энэхүү олон улсын нисэх буудалд дотоод, гадаадын зорчигч тээврийн арилжааны нислэгүүдийг төвлөрүүлэх үүргийг Япон улсаас авсан зээлийн гэрээгээр Монгол Улс хүлээсэн тул батлан хамгаалах болон онцгой байдлын зорилгоор үйлдэгдэх нислэгүүдийг тус буудалд хүлээн авах асуудал нь тодорхойгүй болсон байна.

Улс орны Үндэсний аюулгүй байдлыг хангаж, батлан хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай явуулж байх нь Монгол төрийн үүрэг юм. Мөн сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд өмнөх үед асар их хүч, хөрөнгө, зээл, тусламж, хөдөлмөрөөр бий болж бүтээн байгуулагдсан барилга, объектын зориулалтыг өөрчлөх, хувьчлал нэрийн дор бүлэг этгээдүүд авч завшдаг алдаанууд дахин давтагдах ёсгүй болно.

Манай улс нь өргөн уудам нутаг дэвсгэртэй, тээврийн дэд бүтцийн хөгжил тааруу, хүн амын суурьшил хязгаар нутагтаа сийрэгсэж эзэнгүйдсэн гэх мэт тулгамдсан асуудлууд бий болсон. Алслагдсан нутагт гамшигт нөхцөл байдал бий болоход хамгийн шуурхай төрийн үйлчилгээг хүргэх, авран хамгаалах, эрэн хайх ажиллагааг явуулахад агаарын тээврийн үйлчилгээ ач холбогдолтой. Иймд ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ байна. Олон улсын төвшинд ерөнхий зориулалтын агаарын тээвэр эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд манай улсын агаарын тээвэр ч энэ чиглэл рүү чиглэж байна.

Монгол Улс нь агаарын харилцааны олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ найдвартай хэрэгжүүлэхэд иргэний нисэхийн үүрэг гүйцэтгэлд, аюулгүй байдлын хангамжийн чадвхи чухал юм. Иргэний нисэхийн салбарын дэд бүтэц, нислэгийн аюулгүй байдлын найдвартай ажиллагаа нь улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах хүч хэрэгслийн тулгуур баганын нэг болно.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудлыг 1957 оноос эхлэн үе шаттайгаар хөгжүүлж ирсэн бөгөөд, 1993 онд Азийн Хөгжлийн банкнаас 40 жилийн хугацаатай 30 гаруй сая ам долларын зээлийг жилийн 6 хувийн хүүтэйгээр авч нэлээдгүй бүтээн байгуулалт хийгдсэн. Энэхүү зээлийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалт нь манай улсын иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэхэд бодит дэмжлэг болсон гэж үзэх үндэслэлтэй. Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах бүх чиглэлийн дэд бүтэц бүрэн бий болсон, агаарын хөлгүүдийг засварлах, техникийн үйлчилгээ хийх, засварлах барилга, байгууламжуудын цогц бүрдэл гэх мэтийг зориулалтын дагуу цаашид ашиглаж, ямар ч хөрөнгө шаардахгүйгээр улсын төсөвт валютын орлого оруулж, эдийн засагт бодит дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзэж байна.

0000000065

Иймд Улсын Их Хурлын гишүүн би Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Хөшгийн хөндий дэх олон улсын нисэх буудлыг барихад зориулан Япон Улсын засгийн газраас 20 гаруй тэрбум иен буюу 247 сая ам долларын зээл авсан байдаг, гэтэл 2016 оны байдлаар тус шинэ нисэх буудлын өртгийг 650 сая ам доллар болгож нэмэгдүүлжээ, Засгийн газар зээл нэмэгдүүлсэн шалтгаан нөхцөлийг судалж үзсэн эсэх.

2. Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудалд ажиллах боловсон хүчний орон сууцны асуудлыг хэдэн он гэхэд бүрэн шийдвэрлэх, ямар хөрөнгийн эх үүсвэрээр орон сууц, сургууль, эмнэлэг, цэцэрлэгийг барих.

3. Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудалд ерөнхий зориулалтын агаарын тээврийн үйл ажиллагаанд зориулагдсан нөхцөл бүрдсэн болон хөрөнгө оруулалт хийгдэж буй эсэх.

4. Өмнөх хоёр ч Засгийн Газрын үед Зам тээврийн яам нь Буянт-Ухаа дахь "Чингис хаан" Олон улсын нисэх буудлыг нисэхийн чиглэлээр тухайлбал ерөнхий зориулалтын нислэгийн чиглэлээр үргэлжлүүлэн ашиглах бодлогыг баримталж байсан, энэ бодлогыг хэвээр нь явуулах эсэх.


5. Дэлхий нийтэд агаарын тээврийн салбарын үйлчилгээ тэлж хөгжил хурдацтай явагдаж байгаагийн улмаас нисгэгчийн хомстолд орж, тэдний эрэлт нэмэгдэж байна. Иймд чөлөөлөгдөж буй Чингис хаан нисэх буудлын иж бүрэн объектыг цаашид зориулалтаар нь дотоод, гадаадын нисэхийн мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалт, техник үйлчилгээний нэгдсэн төвийг бий болгож үйл ажиллагаа явуулах эсэх.

6. МИАТ-ын агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын /ангаар/ хамт олон өнгөрсөн онд гадаад улсын 50 дахь том оврын агаарын хөлөгт техник засвар үйлчилгээ хийж ашигтай ажилласан байна. Энэ засварын газрыг энэ чиглэлд нь өргөжүүлэх, эсвэл Хөшигийн хөндий рүү нүүлгэх эсэх

7. Бүсийн нислэгийн удирдлагын төвийн барилгыг 2010 онд Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам 6 тэрбум төгрөгөөр барихаар төсөвлөн тендер шалгаруулан гүйцэтгүүлж 2012 онд 80 хувийн гүйцэтгэлтэй болсон байна. Гэтэл энэ барилгын ажил одоогоор зогсон байна. Энэ хугацаанд тус барилгыг барьж байсан компани шүүхэд алданги тооцон нэхэмжлэл гарган 4 тэрбум төгрөгийг шүүхийн шийдвэрээр авсан байна. Энэ ажлын алдаа эндэгдэлд шинжилгээ хийж хариуцлага алдсан хүмүүст хариуцлага ногдуулсан эсэх, цаашид ямар хөрөнгийн эх үүсвэрээр барьж дуусгах.

Асуулгыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд албан бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ЭНХ-АМГАЛАН